



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах, журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3, Засгийн газрын "Хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах тухай" 2018 оны 01 дүгээр албан даалгавар, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүүхдийн хүмүүжил, тэдний өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах талаар албан хаагчдын мэдлэг, туршлагыг дээшлүүлэх, хүүхдүүдийн авьяас, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий эцэг эхийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Н.Билэгсайхан	Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн дарга
Гишүүд:	П.Отгонцэрэн	Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Биндэрьяа	Хотын хөгжлийн стандартын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Номин	Байгаль орчны стандартын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Цолмонтуяа	Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичиг:	Б.Ундармаа	Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн мэргэжилтэн

2.Эцэг эхийн зөвлөлийн дүрмийг хавсралтаар баталсугай.

3.Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор боловсруулан, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас жил бүр тайлагнаж ажиллахыг Эцэг эхийн зөвлөл (Н.Билэгсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

d:\hotiin_standart\2022_tushaal_blank.docx

1150500068

Газрын даргын 2022 оны 09 дугаар сарын 12-ны өдрийн 425 дугаар тушаалын хавсралт



ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

- 1.1. Байгууллагын Эцэг эхийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү дүрмээр зохицуулна.
- 1.2. Зөвлөлийн үндсэн зорилго нь байгууллагын албан хаагчдийн гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, хүүхдийн хүмүүжил, тэдний өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах талаар албан хаагчдын мэдлэг, туршлагыг дээшлүүлэх, хүүхдүүдийн авьяас, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, тэдгээрийн оролцоог хангуулж ажиллана.
- 1.3. Зөвлөл нь байгууллагын албан хаагчдийн хүүхдийн эрхийг хангах, хөгжүүлэхэд чиглэсэн орон тооны бус зөвлөл байна.
- 1.4. Зөвлөлийн дүрмийг газрын даргын дэргэдэх удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.
- 1.5. Зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллана.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт.

- 2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг дор дурдсанаар сонгоно.
 - 2.1.1. Зөвлөлд орох албан хаагчдийг хамт олны 50-аас доошгүй хувийн ирцтэй сонгож байгууллагын даргын тушаалаар зөвлөлийн гишүүдийг сонгон томилно.
 - 2.1.2. Зөвлөлийн дарга, гишүүд нь /өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх, шилжин явсан, удаан хугацааны сургалт, эрүүл мэндийн гэх мэт хүндэтгэн үзэх шалтгаан/-аар өөрчлөгдсөн бол тухай бүр хуралдаж зөвлөлийн дарга, гишүүдийг шинэчлэн батлуулна.
 - 2.1.3. Зөвлөл нь ажлаа хагас жил бүр Газрын даргад тайлагнаж, улирал бүр хуралдаж, тухайн жил хийсэн ажлаа байгууллагын албан хаагчдийн өмнө тайлагнаж танилцуулсан байна.

Гурав. Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагаа.

- 3.1. Газрын албан хаагчдийн хүүхдийн хүмүүжил, хөгжлийг дэмжих талаар дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллана.
 - Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хөгжилд эцэг эхийн нөлөөллийн талаар лектор урьж илтгэл тавиулах.
 - Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан хүүхдүүдийн дунд насны ангиллаар гар зургийн уралдаан зохион байгуулах.

- Эцэг эх, хүүхдийн хоорондын халуун дотно харилцааг бий болгох, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор насны ангиллаар, спорт буухиа тэмцээн зохион байгуулах.

- Улс, дүүрэг, сургуулийн чанартай тэмцээн уралдаанд амжилт гаргасан, тэргүүний, шилдэг сурагчаар шалгарсан хүүхдэд байгууллагын зүгээс урамшуулал, дэмжлэг үзүүлэх.

- Албан хаагчдыг хүүхэдтэйгээ хамт чөлөөт цагийг өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан аялал, гэр бүлийн зуслан, өдрийн амралт зэрэгт өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, дэмжих:

- Байгууллагын дэргэдэх “Эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөн”-ний зөвлөмжийн дагуу байгууллагын дэргэдэх хүүхдийн танин мэдэхүйн булантай болох. /бичил номын сан/

3.2. Зөвлөлийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар тухайн байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийн төлөөллийг хуралд оролцуулан тэдний санал, хүсэлт, тайлбарын сонсож болно.

3.3. Зөвлөлийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.3.1. Зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлэх,

3.3.2. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх үндсэн асуудлыг тодорхойлох, хурлын товыг тогтоох, зарлах, бэлтгэл ажлыг хангуулах, хурлыг удирдан явуулах, шийдвэрийг батламжлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

3.3.3. Тухайн жилийн батлуулсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад гишүүдийг удирдан чиглүүлж, зохион байгуулан ажиллах.

3.4. Зөвлөлийн гишүүд дараах чиг үүргийг хүлээнэ.

3.4.1. Зөвлөлийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахад оролцох.

3.4.2. Зөвлөлийн дарга буюу хурлаас хариуцуулсан ажил, даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлж, үр дүнг хуралд танилцуулах.

3.4.3. Зөвлөлийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх, хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох албан тушаалтанд шаардлага тавих, түүний биелэлттэй танилцах, тайлбар авах.

3.4.4 Тухайн жилийн батлуулсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад оролцох.

Дөрөв. Бусад зүйл.

4.1. Зөвлөл нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

4.2. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төсвийн холбогдох зардлаас санхүүжүүлнэ.

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН БАЗРЫН ДАРГА

БАТЛАВ.

С. ТӨМӨРДУЛАМ


2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНД
ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцагч, зохион байгуулах	Хамтран хэрэгжүүлэх
1	Албан хаагчид гэр бүл, үр хүүхэддээ зориулж хэрхэн цаг зав гаргадаг эсэх судалгааг гаргаж, эцэг эхүүдэд танилцуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх.	2022.03.28- 2022.04.15	Эцэг эхийн зөвлөл	Байгууллагын албан хаагчид
2	Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хөгжилд эцэг эхийн нөлөөллийн талаар лектор урьж илтгэл сонсох.	2022.05.11- 2022.05.20	Эцэг эхийн зөвлөл, мэдээллийн цаг арга хэмжээ	Лекторууд, Хүүхдийн төлөө төрийн бус байгууллагууд
3	Эх үрсийн баярын өдрийг тохиолдуулан хүүхдүүдийн дунд насны ангиллаар "Ирээдүйн эзэд" гар зургийн уралдаан зохион байгуулах.	2022.05.20- 2022.05.31	Эцэг эхийн зөвлөл	Байгууллагын албан хаагчдын хүүхдүүд
4	Эцэг эх, хүүхдийн хоорондын халуун дотно харилцааг бий болгох, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор насны ангиллаар, спорт буухиа тэмцээн зохион байгуулах.	2022.09.12.- 2022.09.30	Эцэг эхийн зөвлөл	Байгууллагын албан хаагчид гэр бүлийн хамт
5	Улс, дүүрэг, сургуулийн чанартай тэмцээн уралдаанд амжилт гаргасан, тэргүүний, шилдэг сурагчаар шалгарсан хүүхдэд байгууллагын зүгээс урамшуулал, дэмжлэг үзүүлэх.	-	Эцэг эхийн зөвлөл /Байгууллагын удирдлагууд/	

6	Албан хаагчдыг хүүхэдтэйгээ хамт чөлөөт цагийг өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан аялал, гэр бүлийн зуслан, өдрийн амралт зэрэгт өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлэх, дэмжих.	2022.09.30- 2022.10.15	Эцэг эхийн зөвлөл	Байгууллагын удирдлагын Зөвлөл
7	Байгууллагын дэргэдэх "Эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөн"-ний зөвлөмжийн дагуу байгууллагын дэргэдэх хүүхдийн танин мэдэхүйн булантай болох /бичил номын сан/	-	Эцэг эхийн зөвлөл	Байгууллагын нийт албан хаагчид

ХЯНАСАН:
ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:
ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧИГ



Б.УНДАРМАА